



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/05

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.13.4 дэх, заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол бүртгэгдсэн “Ачтан Элит” эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан үйлчлүүлэгч Бат-Өлзий суманд ирж, тандалт судалгаа хийгдэж байгаа тул тус сумаас гарах хөдөлгөөнийг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны 18:00 цагаас 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хориглохыг сумын Засаг дарга (С.Амгалан)-д үүрэг болгосугай.

2.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хууль бусаар нийтийн тээвэр хийсэн тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг 14 хоног түр саатуулж, хуулийн хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат) нарт үүрэг болгосугай.

3.Баян-Өндөр сумаар дамжин Улаанбаатар хот, аймгийн бусад сумдын чиглэлд явдаг гол замуудад 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс хяналтын цэг байгуулж, иргэдийн орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (С.Чулууншагай)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100010